



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/76

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 9-р хороо,
Энх-Энэрэл ӨЭМТ-д балансад
хөрөнгө шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2,138,752 /хоёр сая нэг зуун гучин найман мянга долоон зуун тавин хоёр/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан суурин компьютерийг Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны Энх-Энэрэл “Өрхийн эрүүл мэндийн төв”-ийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг “Нийслэлийн орон сууцны корпораци ХК” /Б.Сүхбаатар/-д зөвшөөрсүгэй.

2. Балансаас балансад шилжин ирж буй хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт зарчмыг баримтлан бүртгэн авахыг Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны Энх-Энэрэл Өрхийн эрүүл мэндийн төв /Г.Ууганцэцэг/-д даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны Энх-Энэрэл Өрхийн эрүүл мэндийн төв /Г.Ууганцэцэг/, “Нийслэлийн орон сууцны корпораци ХК” /Б.Сүхбаатар/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежмент, хувьчлалын хэлтэс /М.Энхболд/-т тус тус үүрэг болгосугай.


ДАРГА Ч.ОДНАСАН



ТТА-2371

• 115050000265

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2019 оны 03 сарын 25 өдрийн
А/26 дугаар тушаалын хавсралт



Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх

Байгууллагын нэр: Нийслэлийн Орон Сууцны Корпораци ХК-аас БЗД-н 9-р хороо, Энх Энэрэл ӨЭМТ-д

№	Хөрөнгийн төрөл	Марк	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ
1	Суурин компьютер	Dell i-3	i-3	ш	2	1,069,376.0	2,138,752.00	2,039,915.78	98,836.22
	Нийт хөрөнгө						2,138,752.00		98,836.22